

ДАНИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА, МОНГОЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Д.Отгончимэг¹

Монгол улсад орчин цагийн дипломат алба үүсч, Гадаад харилцааны яам байгуулагдсанаас хойш 100 жилийг өнгөрсөн онд тэмдэглэсэн билээ. Хэдийгээр манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоогоод 44 жил болж байгаа боловч Монгол, Данийн хоорондын харилцааны түүх зуунаар хэмжигдэх учиртай нь дээр тавьсан илтгэлүүдээс харагдаж байна.

Миний хувьд Герман, Их Британи, Франц, Швейцарь зэрэг дэлхийн их гүрнүүдтэй зэрэгцэн оршиж, эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг ханган, тэдгээртэй өрсөлдөж чадахуйц хөгжил дэвшлийг бий болгон, дэлхийн зах зээлд өөрийн баттай байр сууриа эзэлсэн Дани шиг жижиг орны хөгжлийн туршлага Монгол улсын хувьд ихээхэн сонирхолтой, ач холбогдолтой, суралцах зүйл их гэсэн үүднээс энэхүү илтгэлээ бэлдлээ.

Дани орон нь газар нутгийн хувьд дэлхийд 132-т ордог, Монголын газар нутгаас 36 дахин бага, 43 094 кв.км, хүн амын хувьд 2 дахин их, 5,5 сая. 2010 оны байдлаар ДНБ - 219,3 тэрбум ам.доллар (PPP), нэг хүнд ногдох ДНБ (PPP) - 39545 ам.доллар, жилийн дундаж өсөлт 2,1 хувь. Амьдралын тав тухтай орчин, хүний хөгжлийн үзүүлэлтээрээ дэлхийн тэргүүлэх 10 орны нэг билээ. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2,8 сая, нийт ажиллагсдын 4,5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 19,1 хувь аж үйлдвэрт, 76,1 хувь нь үйлчилгээний салбарт ажилладаг.

Импорт ДНБ-ний 44,9 хувийг, экспорт 50,5 хувийг эзэлдэг. Экспортын гол түншүүд: Герман 17.6 хувь, Швед 13.8 хувь, Их Британи 8.1 хувь, АНУ 5.9 хувь, Норвег 5.6 хувь, Нидерланд 4.8 хувь, Франц 4.7 хувь. Импортын гол түншүүд: Герман 21.1 хувь, Швед 13.7 хувь, Нидерланд 7.3 хувь, Хятад 6.8 хувь, Их Британий 6.1 хувь, Норвег 5.5 хувь, Франц 4.8 хувь, Итали 4.1 хувь. Экспортод машин тоног төхөөрөмж, химийн бодис, ХАА, хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргадаг. Импортоор машин тоног төхөөрөмж, төмөрлөг, түлш, үр авдаг байна.

Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарууд: газрын тос, хий, төмөрлөг, хими, хүнсний үйлдвэр, машин, үүний дотор усан онгоцны үйлдвэр, цахилгаан бараа, барилга, ойн аж ахуй, салхин тээрэм, нэхмэлийн үйлдвэр, бусад. Үйлчилгээний салбарын хувьд банк санхүү, даатгал, аялал жуулчлал, тээвэр, худалдааны салбар өндөр хөгжсөн. Хөдөө аж ахуйн салбарт мах, сүүний чиглэлийн мал аж ахуй давамгайлсан.

¹ МУИС-ийн ОУХС-ийн профессор, доктор (Ph.D)

Дани орон нь үндэс угсаа нэгтэй, цөөн хүн амтай. Тус улсын хөгжлийн загварын онцлог, давуу талаас дурьдвал:

- хүнээ дээдэлсэн нийгэм цогцлоосон улс,
- өндөр өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
- хөдөлмөрийн зах зээлийн нийгэмчлэлийн өндөр түвшин,
- үйлдвэрчний эвлэлүүдийн хүчтэй санал, дуу хоолой,
- эдийн засгийн удирдлага, зохицуулалтад Засгийн газрын онцгой үүрэг,
- хөдөлмөрийн хөлс, татварын харьцангуй өндөр түвшин,
- бүх нийтэд хүртээмжтэй нийгмийн цогц хамгаалалт,
- нийгмийн дундаж давхарга давамгайлсан нийгмийн бүтэц,
- удирдлагын төвлөрлийг сааруулж, нутгийн удирдлагад илүү анхаарал хандуулсан зэргийг хэлж болно.

Ийнхүү Дани орон нь эдийн засгийн хөгжлийн баялаг туршлагатай бөгөөд эдгээрээс Монголд нутагшуулж болох дараах хэдэн асуудлаар Та бүхэнтэй санал бодлоо хуваалцмаар байна.

Нэгдүүгээрт, хөдөө аж ахуйн дагналт, хоршилтоороо Дани орон дэлхийд өөрийн “имидж”-ийг бий болгосон, үүнийг дэлхий нийт болон өөрсдөө даничууд ч хүлээн зөвшөөрдөг. Данийн ХАА олон зуун жилийн туршид үндэсний эдийн засгийн цөм болон хөгжиж аж үйлдвэрийн салбарын бүтцийн үндэс суурийг тавихад онгой үүрэг гүйцэтгэсэн. Данийн ХАА-н салбарт нийт ажиллагсдын 5 хүрэхгүй хувь ажиллаж 15 сая хүн амыг хангахуйц бүтэгдэхүүн үйлдвэрлэж байна. Энэ нь тус орны хүн амын тооноос 3 дахин давсан үзүүлэлт юм. Эндээс үзэхэд ХАА бол валютын орлого олох чухал эх сурвалж юм. Дани орон утсан гахайн махны экспортоороо дэлхийд тэргүүлж (дэлхийн нийт экспортын 70 хувийг нийлүүлдэг), махан консервны экспортоор 2-т (21 хувь), цөцгийн тос, бяслагаар 4-т (12хувь), загасны нийт экспортын 7 хувийг нийлүүлдэг байна.

Монголд газар тариалан, мал аж ахуйн салбарт хөдөлмөрөөр хорших хөдөлгөөн хөдөө орон нутагт нилээд эрчимтэй өрнөж, фермерийн аж ахуйн талаар ч багагүй туршлага, бас сургамжтай асуудлууд ч бий болоод байгаа. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр тэргүүлэх орны хувьд өнгөрсөн зуунд хоршооллын хөдөлгөөнийг үүсгэн хөгжүүлж, амжилтад хүрсэн Дани улсын туршлагыг судлан нэвтрүүлэх нь манай орны хувьд тулгамдаж буй асуудлын нэг юм. Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр хамтын ажиллагааны эхлэл тавигдсан боловч сүүлийн жилүүдэд хумигдсан байна.

Хоёрдугаарт тэмдэглэх нэгэн чухал туршлага нь дэлхийн зах зээл дэх орон зайг мэдрэх, “цоорхойг” олж тогтоох стратеги юм. Гадаадын том өрсөлдөгч нартай тэмцэлдэхийн оронд тэдгээрийн хувьд боломжгүй, эсвэл онцлог байдал, далайц бага зэргээс тэдний сонирхлыг татаагүй тийм орон зай, үйл ажиллагааны онцгой хүрээ, чиглэлийг олж тогтоох нь жижиг орны хувьд оновчтой болохыг Данийн туршлага нотолж байна. Энэхүү үзэл баримтлалын үр дүнд Дани орон дэлхийд хэд хэдэн чиглэлээр тэргүүлэх болсон байна. Ингэхдээ хэрэглэгчдийн сонирхол, шаардлага, онцлогийг нэн тэргүүнд тавьж, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлдэг байна. ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөлжүүлэн Английн зах зээлд тусгай сорт, төрлийн утсан гахайн махыг нийлүүлдэг бол, германы зах зээлд өндөр чанарын шинэ үхрийн мах, Японд мөн тусгай чанарын гахайн махыг нийлүүлдэг байна.

Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд чанарын асуудалд маш их анхаардаг. Жишээлбэл, ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэдэг "Банг ог Олуфсен" гэдэг компаний бүтээгдэхүүний үнэ японы ижил төрлийн бүтээгдэхүүний үнээс 3-5 дахин өндөр боловч чанараар илүү учир дэлхийн худалдаанд ноёрхох болжээ.

Дараагийн нэг жишээ бол эмийн үйлдвэрлэл юм. Мал нядалгааны хаягдлыг ашиглан дэлхийд нэгдүүгээрт тооцогдох болсон өндөр чанарын инсулиныг гаргаж авсан билээ. Дараа нь генийн инженерийн ололтод түшиглэн инсулины үйлдвэрлэлийг улам нарийвчлан боловсронгуй болгож, түүхий эдийн бааз өргөтгөн бусад орноос ялгарах нэгэн шинэ бүтээгдэхүүнийг бий болгожээ.

Гуравдугаарт, шинжлэх ухаан техникийн аливаа ололт амжилтыг цаг хугацаа алдалгүй үйлдвэрлэл хурдан, нэвтрүүлэх нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд нөлөөлдөг нэгэн гол хүчин зүйл болдог байна. Дани бол шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний ажлын санхүүжилтээр дэлхийд тэргүүлж буй 5 орны нэг. Дэлхийн аврага том үйлдвэрүүдтэй харьцуулбал, Данийн компаниуд харьцангуй бага учир өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэхэд уян хатан, шийдвэр гаргахаас эхлээд үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд бага хугацаа зарцуулдаг зэрэг давуу талтай.

Дөрөвдүгээрт, хүрээлэн буй орчныг хамгаалах тал дээр Дани улс дэлхийд үлгэр жишээ болохуйц орон. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын хүндхэн нөхцөлд Дани улс Европын Холбоог даргалах болсон билээ. Энэ хугацаанд ногоон эдийн засаг, ногоон өсөлтийг бодитойгоор хэрэгжүүлсэн төдийгүй байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологиороо ЕХ-ны тэргүүлэгч орны нэг болсон. Эрчим хүчний салбарт экологийн цэвэр технологи нэвтрүүлж, сэргээгдэх эрчим хүчийг (салхи, далайн давалгаа, нарны зай, биомасс, биохий, биоэтанол) хэрэглэснээр нүүрс төрөгчийн хэмжээг бууруулахаас гадна худалдааны багагүй ашиг хонжоо ч олж чадсан байна. Эдийн засгийн ногоон өсөлтийг ХАА, загас агнуур, тээвэр зэрэг салбарт ч хэрэгжүүлсэн байна.

Байгалийн баялаг, эрчим хүчний хэрэглээг өсгөлгүйгээр эдийн засгийн өсөлтийг хангах асуудал нь хүрээлэн буй орчныг хамгаалах асуудалтай салшгүй холбоотой гэж үзэн Дани улс өөрийн туршлагаараа энэхүү хандлага үр дүнтэй болохыг харуулж байна. Тухайлбал:

- Сүүлийн 30 жилд хүн ам өсөж, эдийн засаг хөгжсөн хирнээ усны хэрэглээ 10 хувиар буурчээ.
- Хог хаягдлын 2/3-ыг дахин боловсруулдаг байна.
- Экологийн асуудалд олон нийт, иргэн бүрийн анхаарлыг хандуулж, хүүхэд наснаас эхлээд гэгээрүүлэх ажлыг хийдэг. Копенгаген хотын алдарт Тиволи паркад амарч тоглохоор ирсэн эцэг эх, хүүхдүүдэд бүх төхөөрөмж нь салхины энергээр ажилладаг, энэ нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах зэрэг ухуулга сурталчилгаа, нөлөөллийн ажлыг энгийн хялбар аргаар хийдэг байна. Салхин тээрмийн экспортоор ч тэргүүлдэг орон. Эндээс хүрээлэн буй орчин, эдийн засаг хоорондоо шууд нягт холбоотой болох нь харагдаж байна.
- Жижиг авсаархан автомашин хэрэглэнэ. Гудамжинд зогсоод цэнэглэдэг цахилгаан машин ч бишгүй олон. Даничуудын унах дуртай унаа бол дугуй. Тэдний хувьд нас, нийгмийн, албан тушаалын байр суурь огт хамаагүй, сайд нар хүртэл машины оронд

дугуй унана. Амьдрал нь жигдхэн болохоор хэн хэнээсээ дээш гарах, илүү харагдах гэсэн хөөрүү бодол тэдэнд байдаггүй. Түлш, шатахуун хэмнэхийн тулд бага оврын ачааны дугуй үйлдвэрлэх болсон байна.

Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдол, хүн амын эрүүл мэнд гээд олон асуудлыг шийдвэрлэхэд унадаг дугуйны асуудлыг бодолцох нь зүйтэй болов уу. Гэхдээ энэ асуудлыг тушаал захирамж гаргаснаар шийдвэрлэх боломжгүй, эртнээс бодлого төлөвлөлт, эрх зүйн орчинд тусгах хэрэгтэй юм. Шаардлагатай дэд бүтцийг бий болгох, зам тавих, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, хотын замын хөдөлгөөний дүрэм журамд тусгах гээд олон асуудлыг цогцоор авч үзэх хэрэгтэй. Данид унадаг дугуйны энэхүү орчны эхлэлийг бүр өнгөрсөн зууны 70, 80-аад оноос тавьжээ. Хүн амын дундаж наслалтаараа (эр 77, эм 81) Европод дээгүүр ороход унадаг дугуй бас нөлөөлсөн талтай байж болох юм.

Европын стандартыг Монголд нутагшуулахад Дани улс дэмжинэ гэдгээ албан ёсоор мэдэгдсэн. Дани улстай бид хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи, ноу-хау, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, тухайлбал, био хий, салхины эрчим хүчний чиглэлээр хамтран ажиллахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Тавдугаарт, хөдөлмөрийн зах зээлийн Flexicurity загвар («flexibility» – уян, «security» – аюулгүй байдал, хамгаалал)-ыг дурьдмаар байна. Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбоод улс төрийн ямарваа нэгэн оролцоогүйгээр хоорондоо нийгмийн түншийн ёсоор хэлэлцээр байгуулан мөрддөг. Данид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг улсаас тогтоодоггүй.

Зургадугаарт, жижиг бизнес ба хүчтэй монополиуд харилцан бие биенээ нөхөн хөгжиж ирсэн. Тооны хувьд жижиг, дунд бизнесийн үйлдвэрүүд 95 хувийг, том компаниуд 1-ээс бага хувийг эзэлдэг. Нэг талаас дотоод зах зээлийн багтаамж бага нь том компаниуд хөгжихөд нааштай нөлөөлсөн бол нөгөө талаас гадаад зах зээлд гарах шаардлага нь хөрөнгийн хэмжээгээрээ том гүрнүүдтэй өрсөлдөхүйц үндэстэн дамнасан том корпорациуд гарч ирэхэд нөлөөлжээ.

Данид дэлхийд алдартай дараах том компаниуд байна. Үүнд: P. Moller-Maersk Group, Bang & Olufsen (тоног төхөөрөмж), Carlsberg (шар айраг), «Danisko» (хүнс), Danfoss (машины үйлдвэрлэл, халаалт), Den Danske Bank, Lego (хүүхдийн тоглоом), Novozymes (биотехнологи), Lundbeck (эмийн үйлдвэрлэл) зэрэг юм.

Дүгнэж хэлэхэд, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангасан, олон талт гадаад эдийн засгийн харилцаа бүхий пост үйлдвэржилтийн шинж чанартай орчин үеийн аж ахуйн цогцолборыг Дани улс нь хүмүүн капитал, бизнесийн чадавхи, шинжлэх ухаан техникийн дэвшилд тулгуурлан олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцох замаар бүрдүүлжээ. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, ардчилсан нийгмийг төлөвшүүлэхэд Данийн туршлага, маш няхуур боловсруулсан нийгмийн хангамжийн тогтолцоо, дундчуудад тулгуурласан нийгмийн бүтэц, орлогын шудрага хуваарилалт, улс төрийн тогтвортой байдлыг хангаснаар амьдралын түшингээрээ дэлхийд тэргүүлэх болсон давуу талаас бүтээлчээр суралцах нь бидний хувьд удаан хугацааны туршид баримтлах бодлогын чиглэл байх болов уу.